



САЙНШАНД САЛХИН ПАРК ТӨСӨЛ СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ



**Улаанбаатар хот
2017**

Ерөнхий мэдээлэл:

<i>Төслийн нэр:</i>	<i>Сайншианд салхин парк</i>
<i>Customer</i>	<i>Сайншианд салхин парк ХХК</i>
<i>Байршил:</i>	<i>Дорноговь аймаг, Сайншианд</i>
<i>Баримт:</i>	<i>Сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө</i>
<i>Ангилал:</i>	<i>Нууцлалтай</i>
<i>Бэлтгэсэн:</i>	<i>Тэкол ХХК\Tesol LLC</i>
<i>Бэлтгэсэн огноо:</i>	<i>2016 оны 6 сарын 12</i>
<i>Эмхэтгэсэн:</i>	<i>Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Оюунчимэг</i>
<i>Хянасан:</i>	<i>Төслийн менежер Д.Нандинбаяр</i> <i>Төслийн ахлах менежер Федерика Пелзер</i>

Тэкол ХХК нь Төслийн хөгжлийн төлвийг нарийвчлан авч үзэн, энэхүү баримтыг ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт, ЕХОБ-ны байгаль орчин, нийгмийн стандарт болон Монгол улсын үндэсний хууль тогтоомжуудын шаардлагад нийцүүлэн бэлтгэв.

Энэхүү тайлангийн тухайд

Энэхүү тайланг Сайншианд салхин парк ХХК-ийн (“Үйлчлүүлэгч”) хэрэгцээнд зориулан Монгол улсад хэрэгжих Сайншианд салхин парк төсөлтэй холбогдуулан Тэкол ХХК бэлтгэсэн. Тайланг дараах нөхцөлийн дагуу уншиж танилцана.

Энэ баримт бичгийг төслийн сүлжээгээр дамжуулан бүх ажилтан, албан хаагч авч ашиглах боломжтой. Тогтмол хянаж, шинэчлэгдсэн сүүлийн хувилбарыг цахим хэлбэрээр үзэх боломжтойгоос гадна Үйлчлүүлэгчийн бичгэн зөвшөөрөлд үндэслэн бүх сонирхогч талуудад өгч болно.

Уг төлөвлөгөө шинэчлэх, хадгалах үүргийг төслийн байгаль орчны ажилтан хариуцна. Төлөвлөгөөний эх хувийг гарын үсгээр баталгаажуулж, төслийн бичиг баримтын санд хадгалах шаардлагатай. Хэрэв танд энэ төлөвлөгөөтэй холбоотой лавлах зүйл байвал эхлээд төслийн байгаль орчны ажилтантай холбогдоно уу.

Нууцлал

Тайланд тусгагдсан мэдээллүүд нь тус компанийн өмч бөгөөд нууцлалын зэрэгтэй болно.

Гарчиг

1. ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1. Оршил.....	4
1.2. Зорилго, хамрах хүрээ.....	4
2. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ.....	5
2.1. Танилцуулга.....	5
2.2. Төслийн байршил.....	5
2.3. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ.....	6
3. ХУУЛЬ ЭРХЗҮЙН ШААРДЛАГА.....	6
3.1. Үндэсний хууль тогтоомжууд.....	6
3.2. Олон улсын шаардлага.....	7
3.2.1. ОУСК-ийн шаардлага.....	7
3.2.2. ЭЗ-дын шаардлага.....	8
3.2.3. ЕХОБ-ны шаардлага.....	8
4. СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХАД ЧИГЛЭГДСЭН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ.....	9
5. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛЖ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ.....	12
6. СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	16
6.1. Сонирхогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааны үе шат.....	16
6.1.1. Төслийн барилгын ажлын үе шат.....	16
6.1.2. Төслийн үйл ажиллагааны үе шат.....	16
6.1.3. Төслийн хаалт.....	17
6.2. Олон нийтийн цаашдын оролцоо ба мэдээлэл дамжуулах хөтөлбөр.....	17
6.3. Нөөц бололцоо ба үүрэг хариуцлага.....	21
7. МОНИТОРИНГ БА ТАЙЛАН.....	21
8. САНАЛ, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ.....	22
8.1. Танилцуулга.....	22
8.2. ССП компанийн гомдол, санал барагдуулах механизм.....	25
8.3. Үүрэг хариуцлага.....	25
8.4. Гомдол, саналыг хүлээн авах.....	26
8.5. Гомдол, саналд дүн шинжилгээ хийх.....	26
8.6. Хариу арга хэмжээг тодорхойлох.....	26
8.7. Гомдол, саналын мөрөөр судалгаа хийж, хянах.....	27
ХАВСРАЛТ А. Олон нийтийн санал, гомдлын хуудас.....	29

Үгийн тайлбар ба товчилсон үгсийн жагсаалт

km	километр
kV	киловатт
m	метр
MW	Мегаватт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНЕҮ	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ
БОНиНҮ	Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОННҮ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОНУАТ	Байгаль орчин нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө
ГС	Гүйцэтгэлийн стандарт
ЕКФ	Ekspert kredit fonden
ЕХ	Европын холбоо
ЕХОБ	Европын хөрөнгө оруулалтын банк
ОНХМ	Олон нийттэй харилцах мэргэжилтэн
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
ССП төсөл	Сайншанд салхин парк төсөл
ССП компани	Сайншанд салхин парк компани
СТОХТ	Сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө
ХБОЗХОС	Хөгжиж буй орнуудад зориулсан хөрөнгө оруулалтын сан
СМЕС	Чайна машинери энжинеринг корпорешн
ТББ	Төрийн бус байгууллага
ТБХ	Техникийн бус хураангуй
ЭЗ	Экваторын зарчим
ЭЗСБ	Экваторын зарчим санхүүгийн байгууллага

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. Оршил

Сонирхогч талуудын оролцоог хангах нь нутгийн иргэдтэй хамтран ажиллах, төслийн үйл ажиллагааг амжилттай эрхлэн явуулахад төдийгүй Төслийг улам чанаржуулахад туйлын чухал гэж ССП компани үздэг. Олон нийтийн оролцоог үр дүнтэй хангаснаар аливаа эрдслээс урьдчилан сэргийлэх, Төслөөс ард иргэдэд үзүүлж буй нөлөөллийг ухаалгаар удирдан зохицуулж, улмаар тэдний хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Сонирхогч талуудын оролцоог хангах энэхүү төлөвлөгөөг (СТОХТ) Сайншанд салхин парк (ССП) компанийн захиалгаар Монгол улсын байгаль орчны зөвлөх компани - Тэкол ХХК боловсруулав. Энэ төлөвлөгөө нь Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл болон эрсдлийг тодорхойлох, мөн түүнчлэн сонирхогч талуудтай харилцах, цаашдын хамтын ажиллагаа, харилцан итгэлцлийг бий болгоход Төсөлд туслах зорилготой. Мөн түүнчлэн төслийн үйл ажиллагааг цаашид нийгмийн хэрэгцээ шаардлага, хүлээлтэд нийцүүлэн, сонирхогч талуудтай харилцааг хангах замаар урт хугацааны тогтвортой хөгжлийн үндэс суурийг тавих зорилготой.

СТОХТ нь Амьжаргааг нөхөн сэргээх төлөвлөгөө (АНХТ), Хамтын нийгмийн хариуцлагын төлөвлөгөө (ХНХТ) гэх мэт хэд хэдэн дэд төлөвлөгөөтэй нягт уялдаатай юм. Эдгээр дэд төлөвлөгөөний зарим нь хэдийн бэлэн болсон ба зарим нь боловсруулагдах шатандаа байна.

СТОХТ нь тогтмол шинэчлэгдэж байх юм. Үйл ажиллагаанд өөрчлөлт гарах, эсвэл сонирхогч талуудтай холбоотойгоор шинэ үйл ажиллагаа бий болсон тохиолдолд энэхүү төлөвлөгөө шинэчлэгдэнэ. Мөн түүнчлэн төслийн хэрэгжилтийн явцад тус төлөвлөгөөг тогтмол хугацаанд эргэн хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн засварлаж байх болно.

Энэхүү төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ) хийхэд мөрддөг үндэсний хууль тогтоомж, дүрэм журам, мөн Олон улсын санхүүгийн корпорациас (ОУСК) шаарддаг олон улсын стандартууд болон Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ), Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ), Экваторын зарчмууд санхүүгийн байгууллагууд (ЭЗСБ) зэрэг санхүүгийн бусад байгууллагуудын шаардлагуудын дагуу боловсруулсан болно.

1.2. Зорилго, хамрах хүрээ

СТОХТ-ний гол зорилго нь мэдээллийг олон нийтэд хүргэх, сонирхогч талуудын оролцоог хангах, тэдэнтэй харилцан зөвлөлдөх үйл явцыг тодорхойлоход оршино. СТОХТ нь төслийн нөлөөлөлд өртсөн, мөн төслийн үйл ажиллагааг сонирхогч талуудтай харилцах арга замыг ССП компанид танилцуулна. Төсөл хэрэгжиж буй орон нутаг болон сонирхогч бусад талуудтай харилцан итгэмжтэй, нээлттэй, ил тод харилцааг тогтооход энэхүү төлөвлөгөөний эцсийн зорилго чиглэгдэнэ.

Түүнчлэн, СТОХТ-нд тусгагдсан санал гомдол барагдуулах механизм нь сонирхогч талууд болон олон нийтээс гарсан санал гомдлыг хэрхэн барагдуулах арга замыг тодорхойлсон.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний (БОНИНУ) шаардлагын дагуу сонирхогч талуудтай харилцах үйл ажиллагаа хэдийн эхлээд байна

Энэхүү харилцаа төслийн цаашдын төлөвлөлтөд тусгагдаж, хэрэгжилтийн туршид үргэлжлэх болно.

Энэ төлөвлөгөөнд төслийн гол сонирхогч талуудыг тодорхойлсон бөгөөд хэрэв энд дурдагдаагүй талууд гарч ирэх аваас тэд ССП компанитай холбогдож, цаашид харилцаа тогтоох, мэдээлэл авах

хүсэлтээ илэрхийлэх боломжтой.

2. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Танилцуулга

Сайншанд салхин парк төсөл (Төсөл) нь ОУСК ба Экваторын зарчмуудын шаардлагын дагуу аваад үзвэл В ангиллын төсөлд багтана. Өөрөөр хэлбэл, тухайн төслөөс байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөө ба/буюу эрсдэл нь тодорхой хязгаартай, ерөнхийдөө төслийн талбайгаар нөлөөлөл нь хязгаарлагдах ба нөлөөллийг бууруулах арга хэмжээ авснаар тэдгээрийг нөхөн сэргээх боломжтой байвал түүнийг В ангилалд оруулдаг.


Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- Салхин турбин – 25 ш (Vestas V100-2.2MW)
- Дэд станц
- Салхин турбинуудыг холбох зам; дэд станцыг хатуу хучилттай төв замтай холбох 2 км зам
- Салхин турбинуудыг дэд станцтай холбох, газар доорхи цахилгаан хураагуур
- Төслийн дэд станцыг Сайншанд дахь дэд станцтай холбох 4 км урт цахилгаан дамжуулах шугам (110kV)
- Сайншанд хотод байрлах ажилчдын түр байр

2.2. Төслийн байршил

ССП нь Дорногов аймгийн Сайншанд, Өргөн, Алтанширээ сумдын хилийн зааг нутагт байрлах 486.6 га газрыг 30 жилийн хугацаатай ашиглах зөвшөөрөл авсан.

Төсөл хэрэгжүүлэх талбай нь далайн төвшнөөс дээш 915-1005 метр өргөгдсөн бөгөөд Улаанбаатар хотоос 460 км-т, Монгол орны говийн бүсэд байрлах Сайншанд хотоос зүүн хойш 7 км зайд “Улаан толгойн хөндий” хэмээх газарт оршдог. Төсөл хэрэгжих газрын байршлыг Зураг 1-т харуулав.



Зураг 1.Төслийн талбайн байршил

Салхин турбиныг Улаантолгойн хөндийн урд тал, Хэцүү цавийн хуурай сайр бүхий ухаа толгодын ар нуруу тэгшивтэр өндөрлөг дээр баруунаас зүүн тийш цуваа маягаар байруулна.

Сайншанд хот төслийн талбайд хамгийн ойр буюу баруун хойд зүгт 7 км-г оршдог (Зураг 1). Говийн бүсийн томоохон хотуудын нэг болох Сайншандад нийт 34 000 хүн бүртгэлтэй байдаг бөгөөд тэдний 24 000 нь тус хотод байнга оршин суудаг гэж үздэг¹.

2.3. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ (БОНЕУ), Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг (БОННУ) 2009 онд Байгаль – Экологи ХХК-иар анх хийлгэсэн. 2014 онд БОНЕУ-нд хянан баталгаа хийлгэсэн бөгөөд Монгол улсын Байгаль орчин ногоон хөгжлийн яамнаас (БОНХЯ) тус Төсөлд БОННУ хийлгэх шаардлагатай гэж үзсэний дагуу 2015 онд уг үнэлгээг хийлгэж, ямаар батлуулсан.

ОУСК-ийн шаардлагын дагуу Төсөл нь “В”² ангилалд багтах ба БОНЕУ болон БОННУ-нд Төслийн нөлөөлөл болон үр ашгийг үнэлж (өмнө өгүүлсэнчлэн), тэдгээр нөлөөллийг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг тодорхойлсон.

3. ХУУЛЬ ЭРХЗҮЙН ШААРДЛАГА

3.1. Үндэсний хууль тогтоомжууд

Монгол улсын хууль тогтоомжид Сэргээгдэх эрчим хүчний төслийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн хэлэлцүүлэг хийх ёстой гэсэн тодорхой зүйл заалт байхгүй боловч Байгаль орчны яамны 2014 оны 1 сарын 6-ны өдрийн А-03 тоот тогтоолоор баталсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-д төслийн хэрэгжилтийн явцад олон нийтийн хэлэлцүүлгийг хийх шаардлагатай гэж заасан байдаг. Гэсэн хэдий ч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (1998 онд батлагдаж, 2012, 2014, 2015 онуудад өөрчлөлт оруулсан), Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль (2003 онд батлагдаж, 2006 онд өөрчлөлт оруулсан), мөн Байгаль хамгаалах тухай хуульд (2012) ард иргэд тухайн хэрэгжиж буй төслийн талаар мэдээллээр хангагдах, байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцох эрхтэй гэж заасан байдаг.

Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний (БОННУ) явцад олон нийтийг оролцуулах шаардлагатай гэсэн нөхцөлийг оруулж өгсөн байдаг. Хуулийн 18.4 зүйлд БОННУ-нд тухайн орон нутгийн оршин суугчдын үзэл бодлыг харгалзан тусгахыг шаардсан байдаг. Гэсэн хэдий ч нутгийн оршин суугчдын үзэл бодлыг тухайн төслийн төлөвлөлт болон үйл ажиллагаанд хэрхэн тусгах талаар тодорхой заалт энэ хуульд байдаггүй.

Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн (2003) гол зорилго нь юуны

¹ Сайншанд сумын 3-р багийн дарга Нарангэрэлээс авсан мэдээлэл. 2016 оны 10 сарын 4.

² Байгаль орчин ба/эсвэл нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөө нь ихэнхдээ төслийн талбайг хамарсан, мөн/эсвэл нөлөөллийг нь тодорхойлж, бууруулах арга хэрэгслийг шийдсэн төслүүд В категорид багтана. (Төслийн байгаль орчин, нийгмийн асуудлыг шинжлэхэд зориулан ОУСК-иас гаргасан аргачлал) Түүнчлэн, Салхит салхин цахилгаа станц (Монголын цор ганц салхин станц) В категорид багтдаг.

түрүүнд бүс нутгийн хөгжлийг зохицуулах, мөн нийгэм болон эдийн засгийн зорилгуудын тэнцвэртэй байдлыг хангахад оршдог. Бүс нутгийг хөгжүүлэх үйл явцад орон нутгийн засаг захиргааны эрх мэдлийг хүндэтгэх тухай уг хуульд заасан байдаг. Уг хуульд орон нутгийн засаг захиргааны нэгжүүд нь бүс нутгийн хөгжлийн үйл явцад нутгийн иргэдийг оролцуулах, тэднээс гарсан аливаа асуултуудад хариу өгөх, “иргэд, пүүс, байгууллагууд”-ын уулзалтыг зохион байгуулах үүрэгтэй гэж заасан байна.

3.2. Олон улсын шаардлага

ССП төслийн олон нийтийн хэлэлцүүлэг нь Зээлдүүлэгчийн шаарлагын дагуу хийгдэнэ. Үүнд:

- Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг хангах гүйцэтгэлийн шаардлага (ГШ) (ОУСК ГШ, 2012);
- ОУСК Байгаль орчин, нийгмийн асуудлыг шинжлэх аргачлал (2006 оны 4 сар);
- ОУСК Удирдамж гарын авлага F: Олон нийтийн ярилцлага, мэдээлэл дамжуулах төлөвлөгөө бэлтгэхэд зориулсан гарын авлага;
- Эквадорын зарчмууд (ЭЗ) III 2013;
- Дэлхийн банк групп, Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамж (БОЭМАА-ны удирдамж) 2007;
- Европын хөрөнгө оруулалтын банкны Байгаль орчин, нийгмийн стандарт, эрсдэлийн үнэлгээ ба менежментэд тавигдах стандарт (Стандарт 1);
- Олон нийтийн уулзалт хэлэлцүүлгийг үр бүтээлтэй явуулснаар илүү амжилттай бизнес эрхлэх гарын авлага, сайн туршлага; Мэдээллийг дамжуулах (1998);
- Мэдээллийг дамжуулах, сонирхогч талуудын оролцооны тухай Европын сэргээн босголт, хөгжлийн банкны (ЕСБХБ) гүйцэтгэлийн шаардлага 10 (ГШ)

3.2.1. ОУСК-ийн шаардлага

Гүйцэтгэлийн стандарт #1 төслийн газар нутаг дахь нийгмийн болон байгаль орчны эерэг/сөрөг нөлөөг тодорхойлох болон үнэлэх үйл ажиллагааг дэмжих, хүн ам болон байгаль орчинг сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, хэрэв сэргийлэх боломжгүй тохиолдолд дор хаяж сөрөг нөлөөг багасгах, эсвэл дахин сэргээх, хүн амд нөлөөлж болзошгүй асуудлуудыг мэдэгдэх, мөн компаниудын менежментийн тогтолцоог илүү үр ашигтай болгосноор тэдний нийгмийн болон байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахад чиглэгдэнэ.

Гүйцэтгэлийн стандарт #1 тэгш эрх, хүн бүрт ялгаваргүй хандах, хүүхдийн болон албадан хөдөлмөр эрхлэлтээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй ажиллах орчинг дэмжих, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах зэрэг үндэсний хууль журмын дагуух үйл ажиллагааг хөхиүлэн дэмжихийн тулд ажилчид болон удирдлагын хоорондын харилцааг сайжруулан, хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Гүйцэтгэлийн стандарт #4 нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөө болон эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах, нийгмийг аюулгүй байлгахын тулд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эсвэл түүнийг бууруулах замаар хуулийн хүрээнд ажилчдын аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагааг шаардахад чиглэгдэнэ.

Гүйцэтгэлийн стандарт #5 төслийн газар ашиглалт, үл хөдлөх хөрөнгийг эзэмших үйл ажиллагааны улмаас түүний нөлөөнд өртсөн өрхийн аж амьжиргааг сэргээхэд чиглэгдэнэ.

3.2.2. ЭЗ-дын шаардлага

Экваторын зарчим #5 (Хэлэлцүүлэг ба мэдээлэл дамжуулах), компанийн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн суурин газрын оршин суугчдын ёс заншилд мэдрэмжтэй хандаж, түүнд тохирох хэв маягаар хэлэлцүүлгийг тасралтгүй явуулахыг шаардана. Энэхүү зарчимд хэлэлцүүлэг хараат бус, үнэ цэнэтэй, мөн мэдээллээр хангагдсан, төслийн нөлөөнд өртсөн, мөн өртөж болзошгүй бүлгийн хэрэгцээг олж тогтоосон байхыг шаарддаг.

Экваторын зарчим #6 (Санал, гомдол барагдуулах механизм), компанийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн оршин суугчдын гомдлыг тогтмол, системтэйгээр хүлээж авч, тэмдэглэл хөтлөн тодорхой хугацаанд шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилго бүхий гомдол, санал барагдуулах механизмын тогтолцоотой байхыг шаарддаг.

3.2.3. ЕХОБ-ны шаардлага

ЕХОБ нь Байгаль орчин, нийгмийн шаардлага дахь бодлого, зарчим, стандартуудыг үйл ажиллагаанд хэрхэн тусгахыг тайлбарлан таниулах зорилгоор Байгаль орчин, нийгмийн гарын авлагыг хэвлүүлэн гаргасан.

Стандарт #1 төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө, учрах эрсдэлийг үнэлэх, удирдах, хянах процесст төслийг санаачлаг ямар үүрэг хариуцлагатай болохыг тодорхойлох зорилготой. Европын холбооноос бусад орны хувьд оролцогч болон боломжит оролцогч улсууд нь байгаль орчин, нийгмийн сайн засаглалыг дэмжихтэй холбоотой Европын холбооны зарчим ба стандартад тусгагдсан байгаль орчин, нийгмийн нөлөө ба эрсдэлийн үнэлгээ, менежментийн олон улсын хамгийн сайн туршлагад хүрч очих ёстой.

Стандарт #6: Албадлагын нүүлгэн шилжүүлэлт. Заримдаа ЕХОБ-ны зарим төслүүдийн хувьд нутгийн иргэдийг газар ашиглах эрхийг түр хугацаагаар хязгаарлаж, оршин суугаа газраас нь түр зуур нүүлгэн шилжүүлэх шаардлага гардаг. Стандарт 6 нь төслийн нөлөөнд өртсөн бүх хүн ам, суурин газрын өмч хөрөнгө, тохирох байр сууц, амьдрах стандартыг нь хүндлэн хамгаалах явдлыг гол үндэс болгон баримталдаг. Газар ашиглалтыг хязгаарлах, өмч хөрөнгөө алдсанаас үүсэх сөрөг нөлөөг багасгахыг эрмэлздэг. Түүнчлэн нөлөөнд өртсөн хүмүүсийн амьдралыг дээшлүүлэх, дор хаяж өмнөх аж амьдрал, амьралын стандартыг нь сэргээж өгөх, мөн учирсан алдагдалтай нь тэнцэх нөхөн олговрыг өгөхийг зорино.

Стандарт #8: Хөдөлмөрийн стандарт. Ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой сайн туршлагууд болон зөв оновчтой хууль тогтоомжууд нь ажилчдын тэгш харьцаа, ялгаварлалгүй байдал, адил боломжуудыг хангахад чухал юм. Эдгээр стандартууд нь ЕХОБ-ны төсөл хэрэгжүүлэгчид Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн гол стандартууд болон үндэсний хөдөлмөр болон хөдөлмөр эрхлэлтийн хуулийг дагаж мөрдөхийг баталгаажуулах зорилготой.

Стандарт #10: Сонирхогч талуудын оролцоо. ЕХОБ нь олон нийтийн байгууллага болохынхоо хувьд, мэдээллээр хангагдах эрх болон олон нийтийн хэлэлцүүлэг, оролцоог идэвхитэй дэмждэг. Стандарт 10 нь төсөл хэрэгжүүлэгчдийг зохистой, үр дүнтэй арга замаар төслийн нөлөөнд өртөж буй хүмүүстэй нээлттэй, илэн далангүй, хариуцлагатай харилцан яриа өрнүүлэхийг дэмждэг. Шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах нь зүйтэй бөгөөд энэ үйл явц төслийн бэлтгэл, хэрэгжүүлэлт, хяналтын үе шатуудад чухал гэдгийг онцолдог. Түүнчлэн санал, гомдлыг барагдуулах гэх мэт асуудлыг шийдэх үйл ажиллагаанд талуудын оролцоог хангахыг шаарддаг.

4. СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХАД ЧИГЛЭГДСЭН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Өнөөдрийг хүртэл нутгийн иргэдтэй гурван удаагийн уулзалтыг зохион байгуулсан (Хүснэгт 1-ийг харна уу). Эдгээр уулзалтын гол зорилго нь:

- Төсөл болон БОНиНҮ-ний үйл явцыг тайлбарлах;
- Төслөөс үүсэж болзошгүй нөлөө, цахилгаан дамжуулах шугам, зам, төслийн талбай дээрх бусад барилга байгууламж зэрэг Төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаас үүсэх ашиг тусын талаар ярилцах;
- Орон нутгийн газар ашиглалтын онцлог, төслийн талбай дотор болон ойр орчимд явагддаг үйл ажиллагаа, тэнд амьдардаг хүмүүсийн талаар таньж мэдэх;
- Цаашид мэдээллийг үр ашигтайгаар тараах арга замуудыг тодорхойлох;
- Төслийн нөлөөнд өртөх өндөр магадлалтай сонирхогч талууд болон нутгийн иргэдийн жагсаалтыг гаргах;

Хүснэгт 1. Сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр өмнө хийгдсэн үйл ажиллагаанууд

Он	Оролцогсод	Оролцогс-дын тоо	Байршил	Гол хэлэлцсэн асуудал	Олон нийтээс гарсан гол санал ба асуулт	Төслөөс сууринд ирэх ашиг тус
2009	ССП ХХК Улсын албан хаагчдын төлөөлөл Нутгийн малчид	Нийт 70 Эрэгтэй 36 Эмэгтэй 34	Сайншанд сум	Төслийн байгууламжийн талаар танилцуулан мэдээллээр хангасан. Салхин сэнсний давуу талууд, байгаль орчинд ээлтэй технологи болох тухай, мөн зам дэд бүтцийг сайжруулах, нутгийн оршин суугчдыг болон уурхайн компаниудыг цахилгаанаар хангах тухай дэлгэрэнгүй хэлэлцсэн. Салхин турбиныг ашиглан гаргаж авах эрчим хүч нь хэрхэн цахилгааныг үйлдвэрлэдэг талаар, мөн энэхүү төсөл Монголын хоёр дахь салхин эрчим хүчний станц болох талаар дэлгэрэнгүй танилцуулсан.	Нутгийн малчид болон амьтдын аюулгүй байдлыг хэрхэн хангах, төсөл бэлчээрийн газарт нөлөөлөх эсэх	
2014	Байгаль-Экологи ХХК Улсын албан хаагчдын төлөөлөл Нутгийн малчид	Нийт 45	Сайншанд сум, Алтанширээ сум, Өргөн сум	Байгаль-Экологи БОННУ-ний зорилго, гол үүргийг танилцуулсан. Дэлгэнгүй мэдээлэл байгаль орчны үнэлгээний ажил ба ажлын гүйцэтгэлд бий. Байгаль орчны асуудлууд болон нөхөн сэргээлтийн арга хэмжээний талаар хийсэн уулзалт ярилцлагын талаар мөн бий.	Салхин сэнснүүд цөлжилт үүсэхэд нөлөөлдөг эсэх, төсөл бэлчээрийн газар болон усны нөөцөд нөлөөлөх эсэх, төсөл байгалийн зэрлэг амьтдад нөлөөлөх эсэх	Орон нутагт ажлын байр бий болгох, нутгийн бизнесийн байгууллагуудад ашигтай, ялангуяа барилгын үе шатанд. Орон нутгийн эрчим хүчний чанарыг дээшлүүлэх (хүчдлийн хэлбэлзлийг бууруулна), тогтвортой цэвэр энергийн үйлдвэрлэлийг бий болгоно.
2015	ССП ХХК Байгаль-Экологи ХХК Улсын албан хаагчдын төлөөлөл Нутгийн малчид	Нийт 161	Сайншанд сум, Алтанширээ сум, Өргөн сум	ССП нь төслийг болон Байгаль-Экологи компанийг танилцуулсан. Байгаль-Экологи компани БОННУ-ний үүргийг танилцуулсан. Ингэхдээ тухайн газрын дуу чимээ, үзэгдэх орчин болон эдийн засаг зэрэгт асуудал үүсэх эсхэд анхаарал хандуулах, мөн нутгийн оршин суугчдын санаа сэтгэлийг зовоож буй зүйл байгаа эсэх талаар лавлан асуусан. Салхин станц нь аливаа нөлөөллүүдийг байж болох доод түвшинд хүртэл бууруулах хэрэгтэй гэсэн зөвлөгөөг Байгаль-Экологи компанийн зүгээс өгсөн. Төслөөс нутгийн иргэд ямар ашиг тус хүртэх боломжтой талаар дэлгэрэнгүй мэдээллийг ССП өгсөн. Салхин турбиныг ашиглан цахилгааныг хэрхэн үйлдвэрлэдэг талаар, мөн энэхүү төсөл Монголын хоёр дахь салхин эрчим хүчний станц болох талаар дэлгэрэнгүй танилцуулсан.	Төсөл нь жил бүр болдог морины уралдаанд нөлөөлөх эсэх, усны нөөцөд нөлөөлөх эсэх, турбины эргэлт цаг агаарт нөлөөлөх эсэх,	

Сайншанд салхин парк төсөл

Сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө – Эцсийн тайлан




2016	ССП ХХК Тэкол ХХК Улсын албан хаагчид болон ажилтнууд Нутгийн малчид	Нийт 18	Сайншанд сум	Тэкол компани төслийн нөлөөнд өртсөн малчдын амьжиргааг хэвийн хэмжээнд байлгахад Төсөл хэрхэн санаа тавих талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, нөлөөлөлд өртсөн иргэдийн амьжиргааг нөхөн сэргээх төлөвлөгөөг танилцуулсан.	Төсөл нутгийн малчдыг усны нөөцөөр хангах эсэх. Нутгийн иргэд салхин парсад ажиллах боломжтой эсэх.
------	---	---------	--------------	--	---

5. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛЖ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Янз бүрийн сонирхогч бүлгүүдтэй үр дүнтэй харилцааг тогтоохын тулд ССП компани нь төслийг сонирхож буй, мөн шууд болон шууд бусаар төслийн нөлөөнд өртөж буй хэд хэдэн оролцогч талуудыг тодорхойлсон.

Үүнд төслийн ажилчид болон барилгын гэрээт ажилчид гэх мэт дотоод сонирхогч талууд, мөн төр засгийн байгууллагууд, төрийн бус байгууллага, нутгийн оршин суугчид зэрэг гадаад сонирхогч бүлгүүд багтана.



Зураг 2. Сонирхогч талд дүн шинжилгээ хийх хэрэгсэл³

Тодорхойлсон сонирхогч талуудыг дараах Хүснэгт 2-т харуулав.

³ <https://www.stakeholdermap.com/stakeholder-analysis.html>



Хүснэгт 2. Сонирхогч талууд

Сонирхогч бүлэг	Сонирхогч талууд	Тодорхой сонирхлын талаарх хураангуй	Харилцааны гол хэрэгсэл	Сонирхогч талуудын анализ
Дотоод				
ССП компанийн ажилчид	Компанийн орон тооны болон гэрээт ажилчид	Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны сургалт	Уулзалт, утсаар ярих, имэйл, сургалт	Хэрэгцээг хангах
Ferrostaal Industrial Projects GmbH	Хөрөнгө оруулагч	Төслийг хөгжүүлж санхүүгийн хаадтанд бэлэн болгож өөрийн хөрөнгө оруулалт хийх	Уулзалт, утсаар ярих, имэйл, тайлан	Гол тоглогч
ENGIE	Хөрөнгө оруулагч	Төслийг хөгжүүлж санхүүгийн хаадтанд бэлэн болгож өөрийн хөрөнгө оруулалт хийх ба үйл ажиллагаа болон засвар үйлчилгээг үзүүлэх	Уулзалт, утсаар ярих, имэйл, тайлан	
ХБОЗХОС	Хөрөнгө оруулагч	Өөрийн хөрөнгө оруулалт хийх	Уулзалт, утсаар ярих, имэйл, тайлан	
ЕХОБ	Зээлдүүлэгч	Зээлийн хөрөнгө оруулалт хийх	Уулзалт, утсаар ярих, имэйл, тайлан	
FinnFund	Зээлдүүлэгч	Зээлийн хөрөнгө оруулалт хийх	Уулзалт, утсаар ярих, имэйл, тайлан	
EKF	Зээлдүүлэгч	Зээлийн хөрөнгө оруулалт хийх	Уулзалт, утсаар ярих, имэйл, тайлан	
ЕСБХБ	Зээлдүүлэгч	Зээлийн хөрөнгө оруулалт хийх	Уулзалт, утсаар ярих, имэйл, тайлан	
СМЕС	Инженерийн үйлчилгээ, ханган нийлүүлэлт, барилгын ажил (BoP хэсэг)	Барилга угсралтын ажил хийх, цахилгааны тоног төхөөрөмж нийлүүлэх ба төслийн талбайн менежментийг хийх	Уулзалт, утсаар ярих, имэйл, тайлан	
Вестас	Салхин сэнс нийлүүлэгч	Салхин турбин нийлүүлэх, суурилуулах, ашиглалтад оруулах, засвар үйлчилгээ хийх	Уулзалт, утсаар ярих, имэйл, тайлан	
Гадаад				
Төр захиргааны байгуулага (Үндэсний хэмжээний)	Эрчим хүчний яам	Эрчим хүч үйлдвэрлэлийн үндэсний бодлого, зөвшөөрөл олгох	Бүлгийн уулзалт Тайлан	Гол тоглогч
	Эрчим хүчний зохицуулах хороо	Эрчим хүч үйлдвэрлэлийн үндэсний бодлого, зөвшөөрөл олгох	Мэдээллийн хэрэгсэл	
	Байгаль орчин аялал жуулчлалын яам	Газрыг нөхөн сэргээх		
	Эрүүл мэндийн яам	Ажилчдын болон олон нийтийн аюулгүй		

		байдлыг хамгаалах		
	Барилга хот байгуулалтын яам (Газрын харилцаа, геодези, зурагзүйн газар)	Газартай холбоотой асуудлууд		
	Зам тээвэр хөгжлийн яам (Төмөр замын удирдах газар; Замын хэлтэс)	Зам тээвэртэй холбоотой асуудлууд		
Төр захиргааны байгууллага (Орон нутгийн)	Засаг даргын тамгын газар: <ul style="list-style-type: none"> Дорноговь аймаг Сайншанд сум Өргөн сум Алтанширээ сум Багууд 	<ul style="list-style-type: none"> Газар ашиглах болон эзэмших гэрээ хэлэлцээр хийх (Аймаг болон сум) БОНУ-тэй холбоотой менежментийн үйл ажиллагааны хэрэгжилтийг аймаг хянана. 	Бүлгийн уулзалт Олон нийтийн мэдэгдэл Орон нутгийн чанартай сонин сэтгүүл, мэдээллийн самбар	Гол тоглогч
ТББ/ Холбоод	Дорноговь аймгийн худалдааны танхим ⁴ (хараахан харилцаа тогтоогоогүй) Монголын салхины эрчим хүчний ассоциаци Хөгжлийн төв ТББ ⁵ (хараахан харилцаа тогтоогоогүй) Цагаан лиш хоршоо ⁶ (хараахан харилцаа тогтоогоогүй)	Бизнес хөгжүүлэх боломж	Бүлгийн хэлэлцүүлэг Олон нийтийн мэдэгдэл Орон нутгийн чанартай сонин сэтгүүл, мэдээллийн самбар	Хэрэгцээг хангах
Үйлдвэр ба бизнесийн байгууллагууд	Үндэсний болон орон нутгийн зөвлөх мэргэжилтэн, гэрээлэгч компаниуд Улаанбаатар төмөр зам ХНН Монголын цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК Диспетчерийн үндэсний төв Тосгоны худаг засвар үйлчилгээний компани: Чандмань илч ХХК Удирдлагын төв нь Сайншандад байрладаг Жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг компаниуд (Сайншандын)	Бизнесийн боломж, үнэ хөлс, төлбөрийн нөхцөл Төмөр зам ашиглах, аюулгүй ажиллагаа Цахилгаан эрчим хүчний хангамж, аюулгүй ажиллагаа Цахилгаан эрчим хүчний хангамж, аюулгүй ажиллагаа Цэвэр усаар тогтмол хангах	Олон нийтийн мэдэгдэл Мэдээллийн товхимол Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл	Анхааралдаа авах

⁴ Томоохон төслүүдэд оролцуулах замаар бизнесийг өргөжүүлэх, хөрөнгө оруулагчдыг дэмжих

⁵ Бизнес хөгжүүлэх боломж

⁶ Цагаан идээ нийлүүлснээр эдийн засгийн ашиг олох



		болзошгүй нөлөөллүүд		
Тусгай бүлэг	<ul style="list-style-type: none"> Нутгийн иргэд Төслийн талбайд ойр нутагладаг малчид 	<ul style="list-style-type: none"> Байгаль орчны чанар, газар ашиглалт, нөхөн сэргээлт, барилгын ажлын үеийн замын хөдөлгөөн Ажлын байр болон эдийн засгийн бусад өгөөж Нийгмийн болон олон нийтэд хөрөнгө оруулах боломж/санаачлага 	Бүлгийн уулзалт Ганцаарчилсан уулзалт Олон нийтийн мэдэгдэл Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл	Чухал биш Хэрэгцээг хангах
Хэвлэл, мэдээллийн байгууллага	Өргөн сумын хэвлэл мэдээлэл: <ul style="list-style-type: none"> ‘Өдөр тутмын мэдээ’ & ‘Зууны мэдээ’ (Century News) 	Нутгийн иргэдийн сонирхлыг татах мэдээ мэдээлэл	Бүлгийн уулзалт Олон нийтийн мэдэгдэл	Хэрэгцээг хангах
	Телевизийн нэвтрүүлэг: <ul style="list-style-type: none"> Телевизүүд: Монголын үндэсний телевиз, TV9, MN 25, TV5 Радио: FM 101.5; “Миний төрөлх гэр”, Монголын үндэсний радио 	Нутгийн иргэдийн сонирхлыг татах мэдээ мэдээлэл	Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл Зурагт хуудас	

СТОХТ–г төслийн ОНХМ жил бүр хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчилж байна.

6. СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Сонирхогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааны үе шат

6.1.1. Төслийн барилгын ажлын үе шат

Энэ үе шатанд төслийн барилга байгууламж, зам, дэд бүтцийг барьж байгуулах, харилцагч болон гүйцэтгэгч талуудтай гэрээ хэлцэл байгуулах зэрэгтэй холбоотой бүх үйл ажиллагаа орно (ОУСК, 2012).

Төслийн анхны төлөвлөлтийн үе болон БОНЕУ-ний явцад нутгийн иргэд, сонирхогч талуудтай уулзалт ярилцлагуудыг хийсний үр дүнд төслийн баг тэдний гол асуудалтай танилцаж, төслийн сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, тэдгээрийг хэрхэн удирдан зохицуулах арга хэмжээг Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) болон барилгын гэрээнд тусгах боломжтой болсон.

Барилгын ажил эхлэхэд төслийн нөлөөлөлд буй сонирхогч талуудад барилгын ажлын явцад үүсэж болзошгүй нөлөөллийн талаар танилцуулж байх нь чухал.

Барилгын ажлын явцад сонирхогч талуудын оролцоог хангаж, төслийн БОМТ-нд тусгасан нөлөөллийг бууруулах арга хэмжээ хэр үр нөлөөтэй байгааг үнэлэхэд оролцуулах нь чухал. Ингэснээр тэдний санал, гомдлыг шийдэх, төслийн нөлөөллийг хянах, удирдан зохицуулахад дөхөм болно. Барилгын явцад сонирхогч талуудтай хэр ойр харилцаатай байж, тэдний оролцоог хэр зэрэг хангаж чадахаас төслийн үйл ажиллагааны туршид тэдний харилцаа ямар байх нь шалтгаална. Тиймээс, төсөл хэрэгжиж байх хугацааныхаа туршид сонирхогч талуудтайгаа харилцаагаа улам бүр сайжруулахыг зорих хэрэгтэй юм.

6.1.2. Төслийн үйл ажиллагааны үе шат

Төслийн бүтээн байгуулалт буюу барилгын ажил дуусаж, үндсэн үйл ажиллагаа эхлэхэд аливаа сөрөг нөлөөлөл буурдагтай холбоотойгоор олон нийтээс гарах санал гомдол ч мөн багасдаг. Үүнийг дагаад сонирхогч талуудын оролцоо буурдаг. Түүнчлэн, барилгын гүйцэтгэгч компаниудын гэрээ дуусгавар болсноор ажилчдын тоо эрс цөөрч, энэ нь сонирхогч талуудтай харилцах цаашдын харилцаанд нөлөөлөх боломжтой. Тиймээс ажиллах хүчний бүтэц, бүрэлдэхүүнд гарч буй энэхүү өөрчлөлтөөс улбаатай асуудлыг сайтар бодож боловсруулж, удирдан зохицуулах шаардлагатай.

Сонирхогч талуудын оролцоог хангах асуудлыг төслийн үйл ажиллагааны менежментийн нэг чухал хэсэг хэмээн үзэж, тэдэнтэй уулзалт ярилцлага хийх гэх мэт үйл ажиллагааг тогтмол хугацаанд явуулж байх нь зүйтэй. Тиймээс сонирхогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг компанийн мониторингийн систем болон менежментийн төлөвлөгөөтэй холбохын зэрэгцээ байгаль орчин, эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын менежмент, нийгмийн хөгжил, худалдан авалт болон гэрээ хэлцлийн менежмент, ачаа тээврийн менежмент, аудит болон төслийн эрсдлийн менежмент гэх мэтэд тусгаж өгөх шаардлагатай.

Төслийн үйл ажиллагааны туршид сонирхогч талуудын оролцоог тогтвортой хангахын тулд зөвхөн нөлөөллийг бууруулах арга хэмжээ авахаас илүү зүйлийг хийх хэрэгтэй. Төслийн хэрэгжилтийн явцад сонирхогч талуудын санал бодол өөрчлөгдөх боломжтойгоос гадна сонирхлын шинэ бүлгүүд гарч ирэх боломжтой. Тиймээс эдгээр өөрчлөлтийг тооцсон, илүү уян хатан, нийгмийн болон бизнесийн нөхцөл байдал өөрчлөгдөхөд түүнд нийцүүлэн өөрчлөх боломжтой менежментийг СТОХТ-нд тусгах шаардлагатай.

6.1.3. Төслийн хаалт

Төслийн хаалтын үеийн нөлөөлөлд өртөх магадлалтай сонирхогч талууд нь түүний эхэн үеийнхээс өөр байх магадлалтай. Ажлын байргүй болох, бүс нутгийн эдийн засгийн үйл ажиллагааны үзүүлэлт буурах, компаниас үзүүлж байсан үйлчилгээ зогсох, байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн мониторинг дахь орон нутгийн оролцоо үгүй болох зэрэг нь компанийн нэр хүнд болон санхүүгийн байдалд нөлөөлж болох юм (IFC, 2012).

Тиймээс, төслийн хаалтаас өмнөх бүхий л хугацаанд сонирхогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг идэвхтэй авч хэрэгжүүлснээр компанийн нэр хүндийг өндөрт хадгалах, үүрэг хариуцлагыг бууруулах, гарч болзошгүй зардлыг багасгах боломжтой. Тухайлбал, ийм оролцоо нь төслийн нөлөөлөлд өртсөн байгалийн хэсгүүдийг нөхөн сэргээх, үйл ажиллагааны үед бий болсон дэд бүтцийг олон нийтийн үйлчилгээтэй холбох, ажиллах хүчнийг цомхотгох хөтөлбөр боловсруулах, мөн хөрөнгө санхүүгийн урт хугацааны мониторингод зориулсан хуримтлал ба удирдлагын бүтцийг бий болгох зэрэгт тустай юм.

6.2. Олон нийтийн цаашдын оролцоо ба мэдээлэл дамжуулах хөтөлбөр

Олон нийтийн оролцоог хангах нь Төслийн стратеги төлөвлөгөө, менежментийн төдийгүй өдөр тутмын үйл ажиллагааны нэг чухал хэсэг гэж үздэг. Тиймээс ССП компани Төслийн эхнээс хаалт хүртэлх бүхий л цаг хугацаанд энэ үйл ажиллагааг зохих нөөц бололцоогоор хангаж ажиллана.

ССП компани нь сонирхогч талуудыг Төслийн туршид мэдээллээр хангана. Олон нийтийн уулзалт цуглаан, хурал дээр үгээ хэлэх, санал бодлоо хуваалцах боломжийг сонирхогч талуудад олгож, Төслийн болзошгүй нөлөөллийн талаар танилцуулна.

Эдгээр уулзалт, хурал цуглаан нь зохих хууль журмын дагуу, монгол хэлээр явагдах ба шаардлагатай тохиолдолд англи хэлний орчуулагч ажиллуулна. Уулзалтын тэмдэглэл, тайланг хадгалж, тогтмол шинэчилж байна. Бусад аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог тэдэнд тохиромжтой арга хэлбэрээр явуулна.

Өнөөдрийн байдлаар төслийн менежер олон нийтийн харилцааг хариуцан ажиллаж байна. Төслийн барилгын ажил эхэлмэгц Олон нийттэй харилцах мэргэжилтэнг (ОНХМ) томилох ба тэрээр олон нийттэй харилцах гэх мэт сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөрийг удирдан зохион байгуулах үүрэгтэй.

Төслийн сонирхогч талуудын оролцоог хангах үе шатыг дараах байдлаар ангилж болох юм:

Төсөл боловсруулах шатанд ССП компанийн зүгээс хийсэн уулзалт ярилцлагууд:

- Төсөл байгаль орчны зөвшөөрөл авахын өмнө БОНЕҮ-ний уулзалт ярилцлагыг нутгийн иргэд, сонирхогч талууд болон зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтнуудтай хийсэн.
- БОНИҮ-ний үед орон нутгийн иргэд, сонирхогч талуудын дунд уулзалт зохион байгуулсан.

Хүснэгт 3 болон дараагийн хэсэгт Төслийн туршид ССП компаниас талуудын оролцоог хангахаар төлөвлөсөн үйл ажиллагаа болон Инженерийн үйлчилгээ, ханган нийлүүлэлт, барилгын ажлын (ИҮХНБА) гэрээлэгч нартай харилцах харилцааг тоймлон өгүүлсэн.



Хүснэгт 3. Сонирхогч талуудын оролцоог хангах хөтөлбөр

Үйл ажиллагаа	Танилцуулах шаардлагатай мэдээлэл/ асуудал	Уулзалт болох газар, огноо / харилцах хэлбэр	Хэлэлцүүлэгт оролцох талууд
Барилын ажлын өмнөх үе шат			
Нэмэлт мэдээллийн тайланг танилцуулах	<p>Техникийн бус хураангуй (ТБХ) ба Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаар мэдээлэл.</p> <p>Төслийн сөрөг нөлөөг бууруулах, төслөөс орж ирэх боломжтой үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд барилгын / үйл ажиллагааны болон хаалтын үе шатан дахь нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ</p>	<p>Нэмэлт мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй байлгах үүднээс орон нутгийн хэвлэл мэдээлэл, радио болон цахим хуудсаар дамжуулан танилцуулах.</p> <p>Дараах мэдээллийн хэрэгслүүдээр мэдээллийг сурталчилна:</p> <ul style="list-style-type: none"> ○ ‘Өдөр тутмын мэдээ’, Зууны мэдээ’ ○ FM 101.5 радио <p>Сайншанд суманд зохион байгуулагдах томоохон арга хэмжээний дараа олон нийтийн хэлэлцүүлэг уулзалтыг хийх ба түүн дээр санал гомдлын дэвтэрт бичигдсэн асуудлыг авч хэлэлцэх.</p> <p>Энэ уулзалтыг компанийн талаарх мэдээллийг танилцуулснаас хойш ойролцоогоор 30 хоногийг дараа, олон нийт хүрлэн ирж, оролцох боломжтой газар хийнэ (ж.нь, ямар нэг баяр ёслолын үеэр тааруулж хийх боломжтой).</p> <ul style="list-style-type: none"> ○ Зарлалын самбар, дэлгүүр, хүний хөл ихтэй байгууллага зэрэг газруудад зар мэдээ байрлуулах гэх мэт. ○ Мэдээллийн хуудсаар дамжуулан орон нутгийн бизнесийн байгууллагууд/оршин суугчдад танилцуулсан мэдээлэлд уулзалт болох өдөр, цаг, уулзалтын цар хүрээ, тээврийн үйлчилгээ зэргийн талаар дэлгэрэнгүй өгүүлнэ. ○ Өргөн, Алтанширээ, Сайншанд сумдын олон нийтийн зарлалын самбарт албан ёсны зарлалыг байрлуулна. <p>Энэ хэсгийн талаарх бүрэн тэмдэглэлийг хөтөлж, гарсан асуулт, саналын хариултыг эргүүлэн тайлагнана.</p>	<p>Засаг захиргааны байгууллага ТББ Орон нутгийн иргэд⁷ Олон нийтийн бүлэг Боломжит үйлчлүүлэгч Олон нийт⁸</p> <p>Орон нутгийн иргэд Олон нийтийн бүлэг Засаг захиргааны удирдах ажилтнууд Малчдын төлөөлөл</p>
Барилгын ажил эхлэхийн өмнө	Төслийн талбайг бэлтгэх болон барилгын ажлын хуваарь, замын бүтээн байгуулалт, барилгын	<ul style="list-style-type: none"> • Зарлалын самбар, дэлгүүр, хүний хөл ихтэй байгууллага зэрэг газруудад зар мэдээ байрлуулах 	Орон нутгийн иргэд Олон нийтийн бүлэг

⁷ Орон нутгийн иргэд: Эргэн тойрны орчинд шууд хамаарах бүлэг хүмүүс. Энэ тохиолдолд Сайншанд сумын оршин суугчид юм.

⁸ Олон нийт: Бүс нутгийн бүх хүмүүс. Энэ тохиолдолд Дорноговь аймгийн гурван сумд байгаа иргэд юм (Сайншанд, Алтанширээ, Өргөн сум).



<p>барилгын ажлын өмнөх төлөвлөлтийг хийж, төслийн талбайг бэлтгэх</p>	<p>ажлын үе, үйл ажиллагааны үе, ажилчдын байр барих гэх мэт сонирхогч талуудын голлон сонирхож буй зүйлс.</p>	<p>гэх мэт.</p> <ul style="list-style-type: none"> Нээлттэй уулзалт, олон нийтийн зарлалын самбараар дамжуулан бизнесийн байгууллага, ард иргэдэд мэдээлэл түгээх. Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, радио, телевиз, хэвлэл мэдээллээр зар хүргэх. <p>Байгаль орчин, нийгмийн ажилтнуудын сар бүрийн уулзалт. Дараахаас нэг сарын өмнө:</p> <ul style="list-style-type: none"> Барилгын ажил эхлэхээс Үйл ажиллагааны бусад чухал үе шат эхлэхээс 	<p>Олон нийт ТББ</p>
<p>Санал, гомдол барагдуулах механизмыг танилцуулах</p>	<p>Компанийн ажилчид болон гэрээт компанийн ажилчдын санал, гомдлыг барагдуулах үйл явцыг тодорхойлно. Санал, гомдлоо бие дааж юмуу ажилчдын төлөөллөөр дамжуулан гаргах боломжийг ажилчдад олгоно.</p>	<ul style="list-style-type: none"> Төслийн талбай болон ажлын контор 	
<p>Малчидтай хийх тусгай хэлэлцүүлэг: Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг танилцуулах</p>	<ul style="list-style-type: none"> ТБХ ба БОНН-ийн нэмэлт мэдээлэл. Нөхөн олговрын талаарх мэдээлэл, нөхөн олговрын талаарх харилцан зөвшилцөл Олон нийтийн гомдол, саналыг барагдуулах механизм 	<p>Зорилгод бүлгийн уулзалтыг малчидтай ганцаарчилсан байдлаар юмуу бүлгээр хийж болно.</p> <p>Хугацаа:</p> <ul style="list-style-type: none"> Өвөлжөөг тасалбар болгох өдөр – 2016 -11-15 Зуншлага буюу зуслангийн бэлчээр нь нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдэд нөхөн төлбөр олгоно. Энэхүү нөхөн төлбөр олгогдох өрхүүдийг тодруулах, нөхөн төлбөр олгох үйл явцыг нарийвчлан тодорхойлох ажлыг малчдыг зусландаа буухаас өмнө хийж гүйцэтгэнэ. 	<p>Орон нутгийн иргэд, онцгойлон зорилтог бүлэг болох малчид.</p>
<p>Барилгын ажлын үе шат</p>			
<p>Барилгын үе шатны талаарх ерөнхий мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> Барилгын ажлын төлөвлөгөө Барилгын үйл ажиллагаа Барилгын явц Барилгын ажлын нөлөөлөл, бууруулах арга зам (нөлөөлөлд өртсөн иргэдтэй эргэх холбоо тогтоох боломж). 	<p>Зарлалын самбар, дэлгүүр, хүний хөл ихтэй байгууллага зэрэг газруудад зар мэдээ байрлуулах гэх мэт.</p> <p>Нээлттэй уулзалт, зарлалын самбар, сурталчилгааны материал, сэрэмжлүүлэх тэмдэг зэргээр дамжуулан орон нутгийн бизнесийн байгууллага, оршин суугчдад мэдээлэл хүргэх</p> <ul style="list-style-type: none"> ‘Өдөр тутмын мэдээ’, Зууны мэдээ’ FM 101.5 радио <p>Олон нийттэй харилцах мэргэжилтэн болон төслийн баг сар бүрийн уулзалтад оролцоно.</p>	<p>ТББ Орон нутгийг иргэд Олон нийтийн бүлгүүд Олон нийт</p>



Ажилчидтай харилцан, санал солилцох	<ul style="list-style-type: none"> • Цахилгаан станц ба үйл ажиллагааг тайлбарлах • Ажлын цаг • Барилгын үе шатанд ажлын байр гарах боломж, өргөдөл өгөх үйл явц • Ажиллах хугацаа болон нөхцөл • Хүний нөөц ба БОЭМАА-ны бодлого ба зарчим 	<ul style="list-style-type: none"> • Зарлалын самбар, дэлгүүр, хүний хөл ихтэй байгууллага зэрэг газруудад зар мэдээ байрлуулах гэх мэт. <p>Нээлттэй уулзалт, зарлалын самбар, сурталчилгааны материал, сэрэмжлүүлэх тэмдэг зэргээр дамжуулан орон нутгийн бизнесийн байгууллага, оршин суугчдад мэдээлэл хүргэх</p> <p>Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, радио, сар тутмын уулзалт</p>	<p>Орон нутгийн иргэд Олон нийтийн бүлэг Боломжит ханган нийлүүлэгч Олон нийт</p>
Гомдол саналыг барагдуулах механизмыг танилцуулах	<p>Компанийн ажилчид болон гэрээт компанийн ажилчдын санал, гомдлыг барагдуулах үйл явцыг тодорхойлно. Санал, гомдлоо бие дааж юмуу ажилчдын төлөөллөөр дамжуулан гаргах боломжийг ажилчдад олгоно..</p>	<ul style="list-style-type: none"> • Төслийн талбай болон ажлын контор 	
Үйл ажиллагааны үе шат			
Үйл ажиллагааны үе шатан дахь компанийн гүйцэтгэл	<ul style="list-style-type: none"> • Санал, гомдол барагдуулах механизмыг танилцуулах • Ажилчдын санал, гомдлыг барагдуулах механизм 	<p>Төслийн талбайд</p> <p>Амралтын өрөөн дэх зарлалын самбар, Төсөлд шинэ ажилчид орох үед танилцуулах яриа хийх</p>	<p>Төслийн ажилчид</p>
	<p>БОНУАТ-г жил бүр шинэчлэн тайлагнах</p>	<ul style="list-style-type: none"> • Компанийн тайлангууд • Нийгмийн хариуцлагын хураангуй 	<p>Дотоод</p> <p>Сонирхогч талууд</p> <p>Орон нутгийн иргэд</p> <p>Ханган нийлүүлэгч</p>

6.3. Нөөц бололцоо ба үүрэг хариуцлага

Олон нийтийн оролцоог хангах нь Төслийн стратеги төлөвлөгөө, менежментийн төдийгүй өдөр тутмын үйл ажиллагааны нэг чухал хэсэг гэж үздэг. Тиймээс ССП компани Төслийн эхнээс төслийн хаалт хүртэлх бүхий л цаг хугацаанд энэ үйл ажиллагааг зохих нөөц бололцоогоор хангаж ажиллана.

Төслийн хувьд, сонирхогч талуудын оролцоог хариуцан ажиллах ажилтны үндсэн үүрэг, хариуцлагыг хараахан тодорхойлоогүй байгаа хэдий ч Олон нийттэй харилцах мэргэжилтэн (ОНХМ) болон Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны ажилтан/зөвлөхийг (ЭМААБОА) санхүүгийн хаалтанд хүрэхээс өмнө томилон ажиллуулна.

Төслийн компани барилгын болон үйл ажиллагааны үе шатанд ЭМААБОА авч ажиллуулах ба тэрээр төслийн талбай дээр байрлана. Төслийн ОНХМ нь мөн төслийн талбайд ажиллана.

ЭМААБОА төслийн талбайд ажиллаж буй хүмүүстэй холбоотой ЭМААБО-ны ажлыг санаачилж, удирдан зохион байгуулахын зэрэгцээ ЭМААБО-ны нийцлийг хангаж ажиллах тал дээр төслийн менежер, удирдлага болон ажилчдад дэмжлэг үзүүлэх, туслах үүрэгтэй.

Тэрээр барилгын даамалд ажлаа тайлагнахаас гадна төслийн талбайн менежерт шууд танилцуулна.

ОНХМ нь сонирхогч талууд болон олон нийттэй харилцах өдөр тутмын харилцааг хариуцан ажиллана. Тэрээр орон нутгийн ард иргэд болон бусад сонирхогч талуудын талаарх шинэ мэдээлэл цуглуулах, асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх, үүссэн асуудлын талаар мэдээлэх үүрэгтэй. Мөн түүнчлэн, малчин өрхийн гэрээр очиж уулзах гэх мэтээр талуудтай тогтмол харилцаатай байна.

Төслийн барилгын ажлын явцад болон үйл ажиллагааны туршид ОНХМ өөрийн ажлыг ССП компанийн Гүйцэтгэх захиралд шууд тайлагнана. Мөн тэрээр хуваарьт мониторингийг гүйцэтгэж, СТОХТ-ний хэрэгжилт, гарч буй гомдол саналын талаар компанийн удирдлагууд болон холбогдох талуудад тайлагнана.

Ажилтнуудын ажил үүргийн хуваарь болон холбоо барих хаягт өөрчлөлт гарсан тохиолдолд СТОХТ-г шинэчилнэ.

7. МОНИТОРИНГ БА ТАЙЛАН

Сонирхогч талуудын оролцоог хангаж буй байдалд мониторинг хийснээр дараах зүйлсийг тодруулах зорилготой. Үүнд:

- СТОХТ-нд тусгасан үйл ажиллагааг цагт нь бүрэн дүүрэн хэрэгжүүлсэн эсэх;
- Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсээс гарсан гомдол, саналыг авч үзэж, шаардлагатай тохиолдолд засаж залруулах арга хэмжээ авсан эсэх;
- Сонирхогч талуудын оролцоог илүү сайн хангахын тулд СТОХТ-нд өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэх;

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн товхимол, ганцаарчилсан болон олон нийтийн уулзалт, цуглаан зэргээр дамжуулан ССП компани мониторинг явуулж, шаардлагатай эргэх холбоог үүсгэж ажиллана.

Сонирхогч талуудын санал, гомдлыг барагдуулах, ил тод байдлыг дэмжихийн тулд дотоод мониторинг хийх, нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх болон байгаль орчин, нийгмийн бусад хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь сонирхогч талуудын оролцоог хангах нэг чухал

арга зам юм. Үүний тулд төслийн хэрэгжилтийн явцад сонирхогч талуудтай идэвхтэй харилцаж, олон нийтийн уулзалт ярилцлага дээр ажлаа танилцуулах замаар тогтмол харилцаатай байх шаардлагатай.

Сонирхогч талуудыг олон нийтийн уулзалт ярилцлагад оролцох боломж нөхцөлөөр хангахын тулд тэдгээр арга хэмжээг тэдэнтэй аль болох ойр газарт зохион байгуулна. Олон нийтийн мэдээллийн самбар гэх мэт газруудад санал хүсэлтийн дэвтэр (үзгийн хамтаар) байрлуулж, мэдээллийг нууцаар цуглуулна. Гэхдээ төслийн ажилчид шууд хүрэх газар (гарах хаалга гэх мэт) байрлуулахгүй байх нь зүйтэй. Сонирхогч талуудад хариулт өгөх, харилцан холбоотой байх үүднээс ССП компани мэдээллийг бүртгэж авдаг байна.

СТОХТ болон санал, гомдол барагдуулах механизмд сар бүр мониторинг хийх ба олон нийттэй харилцах харилцааг тогтмол хянадаг байна.

ССП компани нь байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж олон нийтэд танилцуулах ба үүнд Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний (БОНУАТ) техникийн бус хураангуй (ТБХ) багтана. Тайланд БОНУАТ-ний зорилго, хэрэгжилтийн явцыг тусгана.

Төслийн СТОХТ-нд БОАЖЯ-ны тусгай зөвшөөрөл бүхий БО-ны аудитын компани хөндлөнгийн аудит хийх ба аудитын үр дүнг ССП компанид хүлээлгэн өгнө.

8. САНАЛ, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ

8.1. Танилцуулга

ССП нь сонирхогч бүх талуудад нээлтэй байж, тэдний гомдол, саналд аль болох түргэн хугацаанд хариу өгнө. Гарч буй санал, гомдлуудыг зохих ёсоор шийдвэрлэх боломжоор хангахын тулд санал, гомдол барагдуулах механизмыг боловсруулахдаа төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзсэн. ССП компанийн санал, гомдол барагдуулах механизм нь ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт, удирдамжийн дагуу хийгдсэн. Үүнд дараах зүйлс багтана. Үүнд:


- Санал, гомдлыг хүлээн авах, бүртгэх буюу баримтжуулах, шийдвэрлэх үйл ажиллагааг аль болох төвөг багатай, тухайн орон нутгийн соёл заншилд нийцсэн, нөлөөлөлд өртсөн хүмүүст ойлгомжтой байдлаар зохион байгуулна.
- Компанийн болон олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны үеэр энэхүү механизмыг нөлөөлөлд өртсөн иргэдэд танилцуулна.
- Гарсан санал, гомдлыг хэзээ, хэрхэн барагдуулах талаарх шийдвэрийг нөлөөлөлд өртсөн хүмүүстэй хамтран гаргах боломжийг эрэлхийлнэ.
- Санал, гомдлыг хугацаа алдалгүй шийдвэрлэх бөгөөд ингэхдээ нөлөөлөлд өртсөн бүлгийн бүх хэсгүүдэд ил тод, ойлгомжтой байх арга замыг ашиглана. Асуудлыг шийдвэрлэхэд тэднээс ямар нэг үнэ хөлс авахгүй бөгөөд шийтгэл үзүүлэхгүй.
- Хүмүүсийг нас хүйс, нийгмийн давхарга, амьдралын нөхцөл боломжоор ялгаварлахгүй хандана. Ө.х, эрэгтэй, эмэгтэй, эмзэг бүлгийнх гэж ялгаварлахгүй, бүх хүн ижил тэгш эрхтэй байна.
- Тухайн үндэстэн, ястны асуудал, маргааныг шийдвэрлэдэг ёс уламжлал, зан заншлыг харгалзан үзнэ.

- Сонирхогч талуудын санал, гомдлыг хүлээн авч, барагдуулах ажлыг мэргэжлийн, туршлагатай ажилтан хариуцан хийнэ.
- Санал, гомдлыг нь зохих ёсоор шийдээгүй гэж үзсэн хүмүүс өөрсдийн нөхцөл байдлыг гаднын байгууллагаар дахин хянуулах замаар алдааг засаж залруулах механизмыг бий болгоно.
- Хүлээн авсан санал, гомдол, өгсөн хариуг баримтжуулж, олон нийтэд тогтмол хугацаанд танилцуулна.
- Санал, гомдол барагдуулах механизмын дагуу шийдэгдсэн асуудлыг санал гаргагч бүлгүүдэд тогтмол тайлагнана.

Санал, гомдлыг барагдуулах механизм нь төслийн эрсдэл болон нөлөөллийн талаарх олон нийтийн үзэл бодлыг ойлгоход ССП компанид туслах ба компаниас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагаагаа олон нийтийн санал, гомдлыг шийдвэрлэхэд чиглүүлэн зохицуулахад тус нэмэр болдог гэдгийг Гүйцэтгэлийн стандарт болон Удирдамжид онцолсон байдаг.

ССП компанийн хэрэгжүүлж буй төслөөс олон нийтийн санал, гомдлыг барагдуулах механизм буюу үйл ажиллагаа нь орон нутгийн иргэд, малчин өрх, төмөр замын ажилчид гэх мэт төслийн шууд нөлөөнд өртсөн хүмүүсийн гомдол, санал сэтгэгдлийг сонсож, зохих журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Түүнчлэн олон нийтээс хүлээн авсан гомдлын дагуу ямар арга хэмжээ авсан, хэрхэн засаж залруулсныг тогтоож, гарсан үр дүнг мэдээлэх үйл явцыг энэхүү механизмд тусгах учиртай. Сонирхогч талууд нь өөрсдийн санал, гомдлыг улс үндэстнийхээ соёл заншилд харш бус арга хэрэгслээр илэрхийлэх ёстой. Дараах диаграмд санал, гомдол барагдуулах ерөнхий механизмыг харуулав.

Зураг 3. Санал, гомдол барагдуулах механизм



Ажилчдын санал, гомдол

Команийн ажилчид болон гэрээлэгч байгууллагуудын ажилчин, албан хаагчдын санал, гомдлыг барагдуулах механизмыг тусад нь боловсруулна. Санал, гомдлоо бие даан илэрхийлэх, мөн ажилчдын төлөөллөөр дамжуулан гаргах боломжийг ажилчдад олгоно.

8.2. ССП компанийн гомдол, санал барагдуулах механизм

Төслийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үгээ хэлж, асуудлаа шийдвэрлүүлэх найдвартай арга зам орон нутгийн иргэдэд зайлшгүй байх шаардлагатай. Санал, гомдол барагдуулах механизмыг тухайн орон нутагт үндэслэн боловсруулснаар нутгийн иргэд болон компани харилцан уялдаатайгаар асуудлыг хамтран шийдвэрлэх боломжийг бүрдүүлж өгдөг. ССП компанийн боловсруулан хэрэгжүүлэх санал, гомдол барагдуулах механизм нь дараах зорилгыг агуулна:

- Аливаа жижиг санал зөрөлдөөн, маргааныг газар авахуулалгүй, түргэн шуурхай шийдвэрлэх
- Маргааныг орон нутгийн хил хязгаараас давуулахгүй байх
- Санал, гомдлыг цаг алдалгүй, бага зардлаар үр ашигтай шийдвэрлэх
- Эрсдлийг бууруулж, орон нутгийн иргэдийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа өндөржүүлэхэд тустай бизнесийн тогтвортой уур амьсгалыг дэмжин төлөвшүүлэх

Сайтар боловсруулсан гомдол, санал барагдуулах механизм нь дараах ач холбогдолтой:

- Харилцааг үр дүнтэй байлгах суваг болж өгдөг
- Тухайн компани олон нийт болон тэдний сайн сайхны төлөө санаа тавьдаг гэдгийг харуулдаг
- Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулдаг, мөн түүнээс урьдчилан сэргийлдэг
- Харилцан хүндлэл, итгэлцлийг дээшлүүлдэг
- Компанийн засаглалд тогтворгүй байдал үүсгэж буй асуудлыг тодорхойлон шийдвэрлэхүйц зөв бүтцийг бий болгодог
- Үр өгөөжтэй харилцааг дэмждэг
- Компанийн үйл ажиллагааг олон нийтэд хүлээн зөвшөөрүүлдэг

8.3. Үүрэг хариуцлага

Хүснэгт 4. Холбоо барих хаягс

Ferrostaal Industrial Projects GmbH Федерика Пелзер Төслийн ахлах менежер Ferrostaal Industrial Projects GmbH Email: Federica.Pelzer@ferrostaal.com Утас: +49 (0)201 818 1637 Гар утас: +49 (0)171 5666882	Сайншанд салхин парк Д.Нандинбаяр Менежер Сайншанд салхин парк ХХК DHL барилга, 9 давхар Улаанбаатар хот Монгол улс Имэйл: nandinbayar@euro-khan.com Утас: +976-99990416
---	---

ОНХМ томилогдсон даруй дээрх хаяг шинэчлэгдэнэ. Дээрх хаягаас гадна төслийн талбай руу нэвтрэх хаалган дээр орон нутгийн иргэдийн гомдол саналыг хүлээн авах хайрцаг байрлуулна.

8.4. Гомдол, саналыг хүлээн авах

Ирсэн санал гомдол, сэтгэгдлийг Санал гомдлын дэвтэрт нэгтгэн бүртгэх ба бүртгэлийг хийхдээ гомдол, санал гаргагчийн овог, нэр/ бүлгийн нэр, хүлээн авсан огноо, асуудлын товч тайлбар, засаж залруулах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл (хэрэв шаардлагатай бол), гомдол, саналд хариу өгсөн огноог тэмдэглэнэ. Санал, гомдлыг хүлээн авсан тухайгаа 5 өдрийн дотор мэдэгдэж, ажлын 30 өдөрт багтаан хариу өгнө. Хэрэв асуудлыг нягтлан судлахад нэмэлт хугацаа шаардагдахаар байвал энэ тухай гомдол гаргагчид мэдэгдэнэ.

8.5. Гомдол, саналд дүн шинжилгээ хийх

Гомдол, саналд дүн шинжилгээ хийх явцад нөхцөл байдал, гол асуудлын талаар мэдээлэл цуглуулж, түүнийг хэрхэн шийдвэрлэж болох арга замыг тодорхойлно. ССП нь:

- Энэхүү үнэлгээг хариуцан хийх албан тушаалтныг тогтооно. Энэ ажлыг ихэнхдээ санал, гомдлыг барагдуулах ажлыг хариуцсан зохицуулагч гүйцэтгэдэг. Түүнчлэн энэхүү үүргийг үнэлгээний ажилтан юмуу хэлтэст (бүтээгдэхүүн, хангамж, байгаль орчин, нийгмийн харилцаа, ба хүний нөөц) даалгах тохиолдол байдаг.
- Гарсан санал, гомдлын үнэн мөн чанарыг газар дээрээс нь олж харуулахаар компанийг нэг ажилтныг сонгож, шууд тухайн нөхцөл байдал руу илгээнэ.
- Оролцогч талууд, гол асуудал, үзэл баримтлал, санал бодлыг тодруулна:
 - Оролцогч талуудыг тодруулах;
 - Санал гомдолд тусгагдсан гол асуудлыг тодруулах;
 - Компани доторхи болон бусад сонирхогч талуудын үзэл бодлыг цуглуулах;
 - Талуудын төсөөлж байсан анхдагч хувилбаруудыг тодорхойлж, асуудлыг шийдвэрлэх өөр арга замуудыг судлах;
- Санал, гомдлыг ноцтой байдлаар нь (их ноцтой, дунд зэрэг, бага) зэрэглэн ангилна. Хэр зэрэг ноцтой вэ гэдгийг тогтоохдоо компанид болон нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийг харгалзан үзнэ.

Нотолгоотой, хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүсийн сайн сайхан, аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй, аль эсвэл олон нийтийг хамарсан асуудлыг зайлшгүй авч хэлэлцэх ёстой. Түүнчлэн тухайн санал, гомдол хэр зэрэг ноцтой байна вэ гэдгээс шалтгаалан компанийн ямар албан тушаалтан түүнд хариу өгөх нь тодорхойлогдоно.

- “Судал, шийд, зарлан мэдэгд” гэсэн зөвхөн нэг талыг баримталсан бодлогын оронд гомдол, санал гаргагчийг өөрийг нь энэхүү үнэлгээ судалгааны үйл явцад оролцуулж, улмаар асуудлыг шийдвэрлэх хувилбаруудаас сонголт хийх боломжийг олгох нь зүйтэй.

8.6. Хариу арга хэмжээг тодорхойлох

Гомдол, санал гаргагчдад хариу өгөх тогтолцоог бүрдүүлэхдээ *хэнтэй, хэрхэн* харилцах вэ гэдгийг тодорхой заж өгөх шаардлагатай.

Зарим тохиолдолд, гомдол, санал гаргагчтай харилцах, эргэх холбоо тогтоох ажлыг үнэлгээний ажилтан санал, гомдол барагдуулах ажлыг хариуцсан ажилтантай хамтран хариуцах нь зүйтэй байж болох юм.

Гомдол, санал хэр зэрэг ноцтой байна вэ гэдгээс шалтгаалан төслийн талбайд ажиллаж буй менежер энэхүү эргэх холбоог зохицуулах боломжтой.

Гомдол, саналд хариу өгөх арга замыг тодорхойлохдоо ССП компани дараах зүйлсийг

баталгаажуулж өгнө:

- Санал, гомдол хариуцсан ажилтан, эсвэл хэлтэс тасаг тухайн санал, гомдолд хариу өгнө. Уг хариунд тухайн асуудлыг шийдэх *үйл ажиллагааны* талаарх гомдол, санал гаргагчийн үзэл бодлыг авч үзсэн байхаас гадна түүнийг засаж залруулах тодорхой арга замыг тусгасан байна. Түүнчлэн тухайн асуудлыг шийдэх арга замыг санал болгох, аль эсвэл урьдчилсан байдлаар зохицуулах хувилбарыг санал болгох боломжтой.
- Санал, гомдол гаргагчид хариу өгөх, энэ талаар дүгнэн ярилцахдаа гомдол, санал хариуцсан ажилтан, компанийн менежер болон санал, гомдол гаргагч нар хамтдаа уулзана. Хэрэв ийнхүү хамт уулзах боломжгүй бол хөндлөнгийн гуравдагч этгээдийг байлцуулна. Энэхүү уулзалт ярилцлагын үеэр дараагийн шатанд ямар алхмыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар мөн ярилцаж, санал бодлоо солилцоно. Хэрэв тухайн хариулт асуудлыг шийдвэрлэхэд хангалттай хэмээн хүлээн зөвшөөрөгдвөл тухайн гомдол, санал амжилттай шийдэгдэж, улмаар дараагийн алхам хийх шаардлагагүй болно. Харин, хэрэв гомдол, санал гаргагч тухайн хариултад сэтгэл хангалуун бус байвал уулзалтад оролцогсод харилцан хүлээн зөвшөөрөхүйц зөвшилцөлд хүрэхийг хичээх ёстой.
- Хэрэв нөхцөл байдал илүү төвөгтэй, асуудлыг тогтсон хугацаанд шийдвэрлэх боломжгүй нөхцөл үүсвэл гомдол, санал гаргагчид энэ талаар амаар юмуу бичгээр мэдэгдэж, учир шалтгааныг тайлбарлан, дараагийн алхмыг хийх хугацааг санал болгоно.

Бүх санал, гомдолд аман болон бичгэн хэлбэрээр хариу өгөх ба ингэхдээ Санал гомдлын хуудсанд тухайн гомдол гаргагчийн бичсэн хэлбэрийг сонгоно. Санал, гомдол гаргагч нь хариу шаардаагүй тохиолдолд түүнийг санал, гомдол гэж үзэхгүй бөгөөд тиймээс хариулт өгөхгүй.

ССП компани нь хүлээн авсан санал, гомдлыг судалж дууссанаас хойш ажлын 30 хоногт багтаан хариу өгнө. Зарим тохиолдолд хариу өгөх үйл явц 30 хоногоос илүү гарах боломжтой бөгөөд ийм нөхцөлд ССП компани нь гомдол, санал гаргагчид энэ талаар мэдээлж, хэдийд ямар арга хэмжээ авах талаар танилцуулна.

8.7. Гомдол, саналын мөрөөр судалгаа хийж, хянах

Гарсан бүх санал, гомдлыг нэг бүрчлэн нягталж, хянаж байх шаардлагатай. Тэдгээрийг үр дүнтэй нягтлан шалгаж, баримтжуулснаар дараах хэд хэдэн зорилгыг гүйцэлдүүлнэ:

- Тухайн санал, гомдол хэр зэрэг ноцтой (их, дунд, бага) болохыг тодорхой шалгуурын дагуу ангилж бүртгэнэ. Ноцтой байдлын түвшин нь удирдах албан тушаалтанд тавигдах шаардлага, ажлын туршлагыг тодорхойлно.
- Гарч буй санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлүүлэхээр бүртгэх хүртэл бүх процессыг ажиглах үүргийг тодорхой нэг хүнд хариуцна.
- Санал, гомдлыг тогтсон хугацаанд багтаан шийдвэрлэнэ.
- Тухайн нөхцөл байдал болон асуудлыг шийдэх явцад гарсан ахиц дэвшлийг холбогдох бүх хүнд (санал, гомдол гаргагч болон компанийн зохих ажилтан) мэдээллэнэ.
- Шударга ёс, тогтвортой байдлыг хөхиүлэн дэмжихийн тулд компанийн өгсөн хариулт болон үр дүнг баримтжуулан тэмдэглэнэ.
- Сонирхогч талуудын хариу хандлагыг тэмдэглэж, нэмэлт судалгаа, эсвэл зөвшилцөл шаардлагатай эсэхийг тодруулна.
- Асуулыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тэмдэглэл хийх ба энэ нь цаашид адил төстэй асуудлыг шийдэх стандарт ба шалгуурыг боловсруулахад тус болно.
- Тухайн асуудлыг цаг хугацаанд нь бүх талаар шийдсэн гэдгийг батлахын тулд хэрэгжилтэд хяналт хийнэ.
- Санал, гомдлыг барагдуулах явц, үйл ажиллагаа хэр үр нөлөөтэй байсныг үнэлэхийн тулд

чанарыг хянан шалгахад шаардлагатай баримт мэдээгээр хангана.

- Тухайн механизм хэр үр нөлөөтэй болохыг үнэлэх, эсвэл компанийн бодлого юмуу гүйцэтгэлд өөрчлөлт хийхээс өөр аргагүй байдалд хүргэж буй асуудлыг шийдвэрлэхэд хожим хэрэг болохуйц онцгой нөхцөл байдлаас чухам юуг сургамж болгохоор байгааг тодорхойлно.

Гарсан санал, гомдлын мөрөөр эргэн судалж, баримтжуулдаг байхын тулд ССП компани нь дараах зүйлсээр хангана:

- Компанийн ажилтан болон санал, гомдол гаргагчаас мэдээлэл цуглуулах зорилготой *эргэн нягтлах маягт болон үйл явц*
- Санал, гомдлын мэдээллийн санг тогтмол шинэчлэх үүрэг бүхий *ажилтан*.
- Санал, гомдлын ерөнхий чиг хандлага ямар байгааг болон тогтолцооны түвшний учир шалтгаан бий эсэхийг тодорхойлох, ил тод байдлыг хөхиүлэн дэмжих, компани санал, гомдлыг хэрхэн барагдуулдаг болохыг олон нийтэд таниулах, тухайн механизмын үйл ажиллагааг бүхэлд нь тогтмол үнэлэхийн тулд *мэдээллийг тодорхой хугацаанд хянах*.
- Үүссэн нөхцөл байдлын талаар *сонирхогч талуудад мэдээлэх үйл явц* (бичмэл тайлан гэх мэт).
- Санал, гомдол болон тэдгээрийг хэрхэн барагдуулсан талаар тогтмол тайлагнах *үйл явц*.

ХАВСРАЛТ А.

Олон нийтийн санал, гомдлын хуудас

Олон нийтийн санал, гомдлын хуудас

Би, (овог, нэр)

Дараах хаягт оршин суудаг:

Утас:

Факс:

Дараах гомдол / саналыг гаргаж байна (асуудал бүхий газрын байршил, асуудлын цаг хугацааг бичнэ):

Асуудлыг шийдэх санал:

Харилцааны сувгаа сонгох (амаар: уулзалт, утсаар; бичгээр: имэйл, цахим хуудсаар):

Гарын үсэг:

Огноо:

.....